

БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (БОХШХ) нь уурхайн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл болон агуулахыг ашиглах явцад гарч болзошгүй эрсдэлийн үед байгаль орчинд бий болох бохирдол, доройтлыг тодорхойлох зорилготой заавал хэрэгжүүлэх баримт бичиг юм. Хяналт шинжилгээний хөтөлбөрт төслийн нөлөөлөлд өртөх орчин тус бүрийг хянах гол үзүүлэлтүүд, хяналт шинжилгээ хийх давтамж, шинжлэх арга, дээж авах, хадгалах, тээвэрлэх шинжлэхэд баримтлах стандарт шаардлага зэргийг багтаасан болно. БОХШХ-ийг хэрэгжүүлэхдээ энд заагдсан бохирдуулах эх үүсвэрүүдийг хянах Монгол Улсын хууль тогтоомж, стандартчилагдсан арга зүйн хязгааруудыг баримтлах шаардлагатай ба дээрх эрх зүйн актууд, стандартууд шинэчлэгдвэл түүний шинэчилсэн хувилбарыг мөрдөж ажиллах ёстой. Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлж үр дүнг нь доорхи асуудлуудыг тодорхойлох, үнэлэхэд ашиглана. Үүнд:

- Анх таамагласан сөрөг нөлөөллүүдийн хэмжээ, үр дагавараас бодит сөрөг нөлөөлөл, түүний үр дагавар хир зөрж байгааг,
- Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилт болон холбогдох эрх зүйн баримт бичиг, стандарт, дүрэм журамтай нийцэж байгаа эсэхийг,
- Нөлөөллүүдийн эрчим, буурах эсвэл ихэсч байгааг,
- Төслийн БОХТ-ний нийт үр ашгийг үнэлэх зэрэг орно.

Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх, батлагдсан арга зүйг баримтлан стандартчилагдсан багаж, хэрэгслээр дээж, шинжилгээ хийх болон өгөгдлийг боловсруулах ажлыг төслийн байгаль орчны асуудал хариуцсан ажилтанууд удирдан явуулна. Мөн уурхайн олборлолт болон барилгын ажлыг удирдан явуулж буй компани болон бусад гүйцэтгэгч, гэрээлэгч нар энэхүү БОХШХ-ийг үйл ажиллагаандаа баримтлах шаардлагатай. Энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төсвийг тусгасан гүйцэтгэлийн менежментийн төлөвлөгөөг төслийн байгаль орчны асуудал хариуцсан зөвлөх болон ажилтнууд боловсруулж хэрэгжүүлэх хэрэгтэй. Цуглуулсан өгөгдлийг байгаль орчны асуудал хариуцсан ажилтан нэгтгэн, зохих анализыг хийж холбогдох газруудад мэдэгдэж байвал зохино. Гүйцэтгэлийн менежментийн үр дүнг цэвэршүүлсэн усны чанар, нийлүүлж буй ахуйн бохир ус, цэвэршүүлсэн бохир усны хэмжээний харьцаа, тоосжилтыг

бууруулахад цэвэршүүлсэн газрын болон хөрсний чанар, тоосжилтыг бууруулах арга хэмжээ авахаас өмнөх агаар дахь тоосжилтын хэмжээ, арга хэмжээний дараахи тоосжилтын хэмжээний харьцаа зэргээр үнэлнэ. БОХШХ-ийн хэрэгжилт, үр дүн, түүнд хийсэн дүгнэлт зэргийг жил бүрийн 11 -р сарын дотор тухайн орон нутгийн байгаль орчны хяналтын улсын байцаагч, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Байгаль орчин, ногоон хөгжлийн яаманд хүргүүлж хянуулан, дараа оны БОХШХ- ийг батлуулах ёстой. Хяналт шинжилгээний хөтөлбөрийг заавал тусгай эрхтэй мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлж дүгнэлт гаргуулж байх шаардлагатай

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хяналт шинжилгээ явуулах арга, тоног төхөөрөмж	Хэрэгжүүлэх давтамж	Хэрэгжүүлэх хугацаа (он), сая.төг					Нийт зардалс ан.төг	Баримтлах эрхзүйн баримт бичиг,стандарт аргачлал
					2021	2022	2023	2024	2025		
1	АГААРЫН ЧАНАР										
	Тоосжилт (PM10, P5M, PM25);	Салхины зонхилох чиглэл болон эх үүсвэрүүдийн байршил (уурхайн карьер, дотоод тээврийн зам, гадаад овоолго, уурхайн тосгон г.м), нөлөөллийн түвшин зэрэгт тулгуурлан уурхайн орчим дахь агаар бохирдуулагчийн тархалтыг гаргахад төлөөлөх чадвартай нийт цэгүүдэд	Эх үүсвэрүүдийн байршил,нөлөөллийн түвшин зэрэгт тулгуурлан уурхайн орчмын газруудад арга зүйн дагуу	Дотоодын хяналт шинжилгээг сард 1 удаа	0.5	0.5	0.5	0.5	0.5	2.5	MNS 3113:1981. Агаар мандлын бохирдлыг хэмжих аргачлалын ерөнхий шаардлага; MNS 0017-2-3-16:1988 Агаар мандал-Хот, суурингийн агаарын бохирдлын шинжилгээ; MNS 3384:1982. Агаар мандал-Агаарын дээжлэлт шинжилгээ;
Гадаад болон дотоод орчны дуу чимээ, доргио, чичиргээ;	MNS 3113:1981. Хорт утааны ялгаралтыг хэмжих арга;										
Ажлын байрны эрүүл ахуйн үзүүлэлтүүд (тоос, дуу чимээ,	MNS 5061:2001. Нүүрс хүчлийн хий-CO2 тодорхойлох эзлэхүүний арга; MNS 0012-014:1991. Ажлын байрны агаар-Бичил орчинг шинжлэх арга; MNS 0012-1 - 015:1987. Чимээ шуугиан-Ажлын байрны чимээ шуугианыг хэмжих арга; MNS 0017.2.5.12:8988. Хүхэрлэг хий-502 шинжлэх ТХМ буюу аэрозалины арга;										
гэрэлтүүлэг, чийгшил болон физик бохирдлын түвшин);	MNS 0017.2.5.11 - 1998. Азотын давхар исэл.										

	Бохирдлын цэгэн эх үүсвэр (O2,S02,C0)		Эх үүсвэрүүдийн байршил, нөлөөллийн түвшин зэрэгт тулгуурлан уурхайн орчмын газруудад арга зүйн дагуу	Хөндлөнгийн хяналт шинжилгээг жилд 1 удаа	0.5	0.5	0.5	0.5	0.5	2.5	
Нийт дүн сая.төг											

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хяналт шинжилгээ явуулах арга, тоног төхөөрөмж	Хэрэгжүүлэх давтамж	Хэрэгжүүлэх хугацаа (он), сая.төг					Нийт зардал /сая.төг/	Баримтлах эрхзүйнбаримт бичиг,стандарт
					2020	2021	2022	2023	2024		
2	Усан орчин										
	Физик хими, нянгийн бүрэн шинжилгээ, Хүнд металын шинжилгээ, БХХ болон цэвэршүүлсэн бохир усны стандартад заасан үзүүлэлтүүд	Уурхайн ашиглалтын худгууд, ойрын уст цэгүүд	Усны дээж авах сав, хээрийн хэмжилтийн багаж (рН/ЕС/ТйЗ те(ег, TP5-3) зэргийг ашиглан дээж авах ба дээжийг итгэмжлэгдсэн лабораторид өгч шинжлүүлэх	Дотоодын хяналт шинжилгээний хүрээнд улиралд 1 удаа (шинжилгээний үр дүнгээс хамаарч давтамжийг өөрчилж болно)	0.2	0.2	0.2	0.2	0.2	1.0	MNS 0900:1992 Ундны ус- Ундны усны хяналт шинжилгээ; MNS 3935:1986 Ундны ус- Усны

				Хөндлөнгийн хяналт шинжилгээг жилд 1 удаа	0.4	0.4	0.4	0.4	0.4	2.0	шинжилгээн д тавигдах шаардлага; MNS 3936:1986 Ундны ус
Нийт дүн сая.төг					3.0						

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хяналт шинжилгээ явуулах арга, тоног төхөөрөмж	Хэрэгжүүлэх давтамж	Хэрэгжүүлэх хугацаа (он), сая.төг					Нийт зардал /сая.төг/	Баримтлах эрхзүйнбаримт бичиг,стандарт аргачлал
					2020	2021	2022	2023	2024		
3	Хөрсөн бүрхэвч										
	Ялзмаг, урвалын орчин (pH), давсжилт, карбонат (CaCo3), хөдөлгөөнт кали (K20), хөдөлгөөнт фосфор (P205), Шингээгдсэн сууриуд Ca, Мд Механик бүрэлдэхүүн, чулуу, чийг, амь чийг, эзлэхүүн жин	Ил уурхай, овоолго, ажилчдын тосгон, засварын газар, хогийн цэг орчимд	Итгэмжлэгдсэн лабораторийн задлан шинжилгээ	Хөндлөнгийн хяналт шинжилгээг жилд 1 удаа	0,2	0,2	0,2	0,2	0,2	1,0	MNS 2305-94 Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам; MNS 3298-1991 Шинжилгээний дээж авахад

	Хар тунгалаг (РЬ), кадми (Сб), хром (Сг), цайр (Zn), никель (i), Мөнгөн ус (Нд), цианид натри, хүнцэл (Аз)	Засварын газар, хогийн цэг орчимд		Хөндлөнгийн хяналт шинжилгээг жилд 2 удаа	0,4	0,4	0,4	0,4	0,4	2,0	гавигдах ерөнхий шаардлагууд; MNS 5850:2008 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ; MNS 5850:2008 Хөрсний чанар. Хөрс бохирлууллагч
Нийт дүн сая.төг					3,0						

Дорнод аймгийн Хэрлэн, Баянтүмэн сумын нутгийн хилийн заагт орших Адуунчулуун нүүрсний уурхайн орчны хяналтын цэгүүдийн байрлал

